

**МОНГОЛ ДАХЬ НАМЫН СИСТЕМИЙН ХЯМРАЛТ  
БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ**

**Г.ЦЭНД-АЮУШ**

*Доктор, дэд проф. МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс Төр Судлалын тэнхим*

**Түлхүүр үг:** улс төрийн нам, намын систем, намуудын өрсөлдөөн ба эвлэрэл

**Краткий обзор:** В статье на основе политических реалий показано, что многопартийная система, получившая развитие в Монголии на волне радикальных демократических преобразований, находится в состоянии непрерывного кризиса. Рассмотрены признаки и главные причины кризиса, особенности современной трансформации многопартийности. Существенными моментами, характеризующими в последние годы отношение масс к многопартийной системе, являются низкий уровень доверия к политическим партиям, отсутствие интереса к их деятельности, слабость связей больших групп населения с партийно-политическими институтами. Все заметнее становятся признаки ослабления оппозиционных парламентских партий, не возможность конкурировать с правящей партией на равных условиях и укрепляются барьеры, препятствующие появлению новых авторитетных политических сил, способных оздоровить политическую жизнь страны. Это отражает кризис партий как политического института и свидетельствует о трансформации политической системы в целом.

1990 оны ардчилсан хувьсгалын дараагаар Монголын нийгмийн амьдралын бүх талыг хамарсан ардчилсан өөрчлөлтийг хэрэгжүүлж эхлүүлснээс хойш даруй 25 дахь жилтэйгээ золгож байна. Энэхүү шилжилт зарчмын хувьд тэс хоёр өөр тогтолцооны (авторитари ба ардчилсан) хооронд<sup>1</sup> өрнөж буй учир монгол түмний бүтээж бий болгосон ололтуудтай зэрэгцээд хүндрэл бэрхшээлүүд дагалдсаар байгаа нь өнөөгийн Монголын нийгмийн амьдралын бодит хямралт үзэгдэл болтлоо хүлээн зөвшөөрөгдлөө. Английн нэрт судлаач К.Поппер “Диктатураас ардчилалд шилжих нь ардчиллаас диктатурт эргэн шилжихээс хэдэн зуу дахин төвөг бэршээлтэй үйл явц” гэж бичиж байсаны нотолгоо энэ.

Бид энэхүү өгүүлэлдээ Монголын улс төрийн намууд, намын системд нүүрлээд байгаа хямралт байдлын шалтгаан, шинжүүд, үр дагаварын талаар “Политологи” сэтгүүлийн энэ дугаарын хуудаснаа санал бодлоо хуваалцах зорилго тавьсан юм.

1990 он гарсаар Монголд улс төрийн засаглалын шинэ харилцааны улс төр, эрх зүйн үндэс тавигдаж улмаар 1992 оны бидний мөрдөж буй шинэ Үндсэн Хуулиар баталгаажсанаар улс төрийн янз бүрийн үзэл баримтлал бүхий олон намууд бий болж, олон намын систем бодитойгоор оршин үйлчлэх болсон нь монгол түмний улс төрийн амьдралд гарсан цоо үзэгдэл байлаа.

“Намын систем” хэмээх ойлголтыг намуудын жирийн тоон нийлбэр бус, төрийн бодлого шийдвэрийг боловсруулж, шийдвэр гаргах төвшинд улс төрийн намуудын оюуны чадамжийг хоршуулж оновчтой хувилбарт хүрэх үйл ажиллагааны зохистой механизм мөн гэж чанарын талыг нь илтгэсэн улс төрийн шинжлэх ухааны парадигмыг үндэс болгох учиртай.

Манайд үйл ажиллагаа явуулж буй улс төрийн намуудын мөрийн хөтөлбөртөө тавьсан зорилгыг харьцуулан шинжлэхэд бүх намуудын хувьд үндсэндээ “үндэсний эрх ашгаа дээдлэх, тусгаар тогтнол, тогтвортой хөгжиж нөхшлийг бүрдүүлэх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэх, хүн ардынхаа сайн сайхан амьдралыг хангах г.м” нийтлэг зорилго тэргүүн эгнээнд тунхаглагдсан байдаг. Гэтэл бодит байдал дээр улс төрийн системийн хамгийн гол бүтцийн, мөн чиг үүргийн субъект болсон улс төрийн намууд дээрх тунхагласан эрхэм “туйлын” зорилгоо санаатай санаагүйгээр умартан “засаглалын төлөөх” өрсөлдөөн тэмцэл тэргүүн зэргийн “зорилго” болгож байгаа нь намын системийн хямралын үндсэн шалтгаан мөн бөлгөө. Үүнээс үүдээд “засаглалын төлөөх” намуудын хоорондын тэмцэл гүнзгийрэн даамжирч “засаглалын төлөөх” намуудын доторх талцсан “фракц, талцаж тунисан бүлэглэлүүдийн” тэмцэл болж өрнөж байгаа нь намын систем хямралд автсаныг илтгэх нэг шинж.

Чиг үүргийн талаас нь авч үзвэл улс орны хөгжлийн талаар баримтлах (ойрын, дунд, алс хэтийн) чиг шугамыг тодорхойлох бодлогын намууд байх ёстой. Бодит байдал дээр энэ чиг үүрэг аль ч эрх барьж буй нам дээр тодорхойгүй, тухайн цаг үеийн байдлыг илүүд үзсэн “хойд хормойгоо авч урд хормойгоо” нөхөх цагийн аяс, олон түмний ундуйсал, дургүйцлийг “горьдлого” төрүүлсэн сайхан төсөл, сэдлүүдээр намжаах бодлогыг хэрэгжүүлж “хамтарсан”, эсхүл “шинэчлэлийн”, “шийдлийн” засгийн газрыг байгуулж ирлээ. “Улс төрийн бодлогыг зүрхээр биш, ухаанаар явуулдаг юм гэдгийг

<sup>1</sup> Транзитологи-тогтолцооны шилжилтийг судлах ухаан

ойлгоход олон жил хэрэгтэй”<sup>2</sup> гэж судлаач Фейхтвангер бичсэн байдаг. Энэ байдал намын системийг төдийгүй, УИХ-ыг улс орныг хямралт байдалд орууллаа.


Намуудын дотоод бодлогод ч гарч буй өөрчлөлтүүд гол төлөв “дээрээс” төлөвлөгдөж, намын зиндаархдаг мяндагтан эрхэмүүд нь гишүүд дэмжигчдээсээ тасраад гаднаасаа төдийгүй “дотроосоо” хурцхан шүүмжлэл, эсэргүүцэлд өртөөд байгаа нь намуудын хямралын бас нэг шинж мөн. “Нам өөдөө гарахдаа тулгуураа, оройд гараад тэнцвэрээ бодох хэрэгтэй” гэж Ф.Беконь бичсэн хатуухан сануулгыг гэрчилж байна.

Улс төрийн намаар халхавч хийж бас хаацайлагддаг явцуу бүлэглэлүүдийн хуйвалдаан нам дамжсан хэлбэрт орж эрх мэдлээ хадгалах тоглолт хийж байгаа, нөгөө талаас тэдний өрсөлдөөн ямар ч дүрэмгүй болсон нь улс орон, нийгмийн хөгжилд тээг садаа болж байна. Ийм нөхцөл байдлын улмаас манайд далд, бохир хуйвалдааны улс төр зохилох болж Үндсэн Хуулийг ч сахихаа байв.

Өнөөгийн УИХ дахь шийдвэрийг олонхоороо гаргадаг тогтолцоо нь намын системийн “оновчтой” байх зарчимтай зөрчилдөж сөрөг хүчин “хүч мөхөсдөх”, цөөнхийн эрхийг хуулиар далайлган боомилох, “бялуу хуваалцах” аргаа барсан байр суурьт түлхэх шалтгаан болж байгаа нь намуудын хоорондоо бодлого оюунаараа өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж улс төрийн амьдралыг эрүүлжүүлэх нөхцөл бололцоо хумигдаж байгаа нь намын системийн хямралын бас нэг шинж юм.

Олон түмний дунд явуулсан судалгааны байгууллагуудын судалгааны статик мэдээг үзэхэд сүүлийн жилүүдэд намуудын рейтинг байнга уруудан унасан, иргэдийн намуудад итгэх итгэл ихэд суларсан үзүүлэлт зонхилдог нь дээрхийн нотолгоо мөн. Эндээс намууд (ялангуяа эрх баригч) УИХ-д “намын засаглалаа” тогтоох гэж зүтгэх нь гол биш, харин олон түмний санаа бодлын сэтгэл ханамжид нийцсэн өөрчлөлт, шинэтгэл намуудад, намын системд төдийгүй, улс орны хэмжээнд үгүйлэгдэж байна. Германы социологч Э.Дюркгейм “Шинэ нийгэмд шилжих зан суртахууны үндсийг бий болгоогүй нөхцөлд эдийн засаг, улс төрийн хамгийн зөв шийдвэр ч бүрэн хэрэгжиж чадахгүй” гэж хэлсэн нь өнөөгийн нийгэмд тулгараад байгаа хямралт нөхцөлт байдлын нотолгоо болж байна.

Улс орны нөхцөл байдлын талаарх олон түмний санал бодлыг тандахад:




Прогноз хүрээлэн, Социум агентлаг, Тандалт судалгааны төвөөс хийсэн судалгааны дээрх дүнгээр улс орны нөхцөл байдлын талаар хэвийн, дунд зэргийн гэх үнэлгээ даруй 10% гаруйгаар буурсан байхад хямралт байдлыг хүлээн зөвшөөрсөн үнэлгээ мөн 10% гаруйгаар өссөн ба 3 хүн тутмын нэг нь байх жишээтэй<sup>3</sup>.

<sup>2</sup> Фейхтвангер Л. Соб. Соч. т.64 М., 1994, с. 125

<sup>3</sup> Социологийн судалгааны дүн. УБ., 2014.

Улс орны нөхцөл байдал ойрын ирээдүйд хэрхэн өөрчлөгдөх бол?



Энэ судалгааны дүн улс орны нөхцөл байдлын ирээдүй тун бүүдгэр байгааг тайлбарлалт нэхэхгүйгээр харуулж байна.

Иймээс улс төрийн намуудын шударгаар өрсөлдөх чадварт адил тэгш боломж олгох, бүрдүүлэх “тоглоомын дүрэм” боловсруулахад улс төрийн намуудын хуульд өөрчлөлт шинэчлэл хийх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Чингэж байж олон түмэнд хамгийн хүртээмжтэй, олон ургальч чиг хандлагад суурилсан, эх орон, ард иргэдийнхээ язгуур эрх ашгийг илтгэсэн ажил хэрэгч олон намын системийн тогтолцоог бүрдүүлэх боломжтой гэж бид үзэж байгаа юм.

#### НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Үндсэн Хууль. УБ.,1992
2. Улс төрийн намуудын тухай хууль. УБ., 2005
3. МАН, МАХН, АН, МУНН, ИЗНН намуудын мөрийн хөтөлбөрүүд
4. МАН-ын дүрэм. УБ.,2013
5. Ардчилсан намын Үндсэн дүрэм. УБ.,2006
6. Эх-Орон намын дүрэм. УБ., 2007
7. Монгол улсын их хурлын сонгуулийн дүн./ 1992-2012/. УБ., 2012
8. Прогноз хүрээлэн. Социум агентлаг. Тандалт судалгааны төв. УБ., 2014.
9. Д.Ганхуяг. Хямралын үр, түүнд тавих онош. Социологи сэтгүүл. 2007. №265/35/
10. Козырева.П.М. Смирнов. А.И. Кризис многопартийности в России. Полис. 2014.№4 Фейхтвангер.Л. Соб. Соч.т.64. М.,1994, с. 125